



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2021 оны 11 сарын 11 өдөр

Дугаар 493

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө балансаас балансад
шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8 дахь хэсэг, 30 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Засгийн газрын 2019 оны 168 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 5.1, 5.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. "Эрдэнэсант-АЗЗА" төрийн өмчит хувьцаат компанийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, 26,281,250.00 (хорин зургаан сая хоёр зуун наян нэгэн мянга хоёр зуун тавин) төгрөгийн балансын үнэ, 13,140,625.00 (арван гурван сая нэг зуун дөчин мянга зургаан зуун хорин таван) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан хөрөнгийг "Увс-АЗЗА" төрийн өмчит хувьцаат компанид балансаас балансад шилжүүлсүгэй.

2. "Эрдэнэсант-АЗЗА" төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Б.Золжаргал, "Увс-АЗЗА" төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Ц.Цэдэнбал нарт дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Хөрөнгө хүлээлцэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2021 оны 4 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,

АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2021 оны 11 дүгээр сарын 11-ны өдрийн 493
дугаар тогтоолын хавсралт

**"Эрдэнэсант-АЗЗА" ТӨХК-ийн хөрөнгөд бүртгэлтэй хөрөнгийг "Увс-АЗЗА" ТӨХК-
д балансаас балансад шилжүүлэх хөрөнгийн жагсаалт**

№	Хөрөнгийн нэр	Ашиг лалтад орсон он	Тоо хэм жээ	Балансын үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэгдэл өртөг (төгрөг)
1	SLB-10 маркийн асфальто бетон завод	2012	1	26,281,250.00	13,140,625.00	13,140,625.00
	ХӨРӨНГИЙН НИЙТ ДҮН			26,281,250.00 (хорин зургаан сая хоёр зуун наян нэгэн мянга хоёр зуун тавин)	13,140,625.00 (арван гурван сая нэг зуун дөчин мянга зургаан зуун хорин таван)	13,140,625.00 (арван гурван сая нэг зуун дөчин мянга зургаан зуун хорин таван)